



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 363

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 3, 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн бүрэлдэхүүн сургуулиудын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, нийт 46,320,900 (дөчин зургаан сая гурван зуун хорин мянга есөн зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан 4 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын үүрэг гүйцэтгэгч Ж.Цолмонд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтын хамт 2020 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

300621

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 07 дүгээр сарын 08-ны өдрийн
363 дугаар тогтоолын хавсралт

**АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛИУДИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

д/д	Автомашини марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Нэг бүрийн үнэ /төгрөг/	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Сэргээн босголтын зардал /төгрөг/	Худалдах доод үнэ /төгрөг/
1.Дорноговь Анагаах Ухааны Сургууль							
1	УАЗ-22069-030,23-51 ДГА, суудлын, Арал 60475717	1996-2008	345408	11,358,600.00	11,358,600.00	-	800,000.00
2.Дархан-Уул Анагаах Ухааны Сургууль							
1	Ландровер- 62-63 ДАХ, суудлын, 2157957, Арал 591250	2000-2008	195000	18,962,300.00	18,962,300.00		3,000,000.00
2	Рекстон, 87-20ДАР, суудлын, Арлын№-14Р-112833	2004-2012	170392	14,000,000.00	14,000,000.00		3,000,000.00
3	Истана, 36-80ДАХ, суудлын, арал KPDGBDH812P160081	2002-2016	184479	2,000,000.00	2,000,000.00		800,000.00
	НИЙТ ДҮН			46,320,900.00	46,320,900.00		7,600,000.00
				(дөчин зургаан сая гурван зуун хорин мянга есөн зуу)			(долоон сая зургаан зуун мянга)